



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар АИИС

Улаанбаатар хот

**Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээний
төв” ОНӨААТҮГ-ын балансаас
хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 7,422,300.00 (долоон сая дөрвөн зуун хорин хоёр мянга гурван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Хан-Уул Агро” ОНӨААТҮГ (Ц.Цогтсайхан), “Хан-Эко тээвэр” ОНӨААТҮГ (Н.Наранцацрал)-т балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээ төв” ОНӨААТҮГ (Ц.Эрдэнэбаатар) зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг “Хан-Уул Агро” ОНӨААТҮГ (Ц.Цогтсайхан), “Хан-Эко тээвэр” ОНӨААТҮГ (Н.Наранцацрал)-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг “Хан-Уул Агро” ОНӨААТҮГ (Ц.Цогтсайхан), “Хан-Эко тээвэр” ОНӨААТҮГ (Н.Наранцацрал), Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээ төв” ОНӨААТҮГ (Ц.Эрдэнэбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М. БАЯРАА

11505000075
Тушаал-2021